



ӨМНӨГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

20~~21~~ оны 04 сарын 01 өдөр

Дугаар 60

Даланзадгад сум

“Сурагч солилцоо” хөтөлбөр батлах тухай

Монгол Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 “ж”, 19 дүгээр зүйлийн 19.1, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, Засгийн газрын 2019 оны 200, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 2/4 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Сурагч солилцоо” хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.
2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг жил бүр баталж, арга хэмжээний зардлыг жил бүрийн аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө, орон нутгийн төсөвт тусгаж ажиллахыг аймгийн Засаг дарга /Р.Сэддорж/-д даалгасугай.
3. Боловсролын мэргэжлийн болон сургалтын байгууллага, төр, төрийн бус байгууллага, олон нийтийн оролцоонд түшиглэн хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлж, хөтөлбөрийн тайланг жил бүрийн нэгдүгээр улиралд багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг дарга /Р.Сэддорж/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Б.БАДРАА



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2021 оны 04 дүгээр сарын 01-ний  
өдрийн 60 дугаар тогтоолын хавсралт

## “СУРАГЧ СОЛИЛЦОО” ХӨТӨЛБӨР

### Нэг. Хөтөлбөрийн нийтлэг үндэслэл

Дэлхий нийтээрээ даяаршиж буй өнөөгийн нийгэмд хурдацтай хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн нийгэмд бие даан суралцах, бусад орны хэл соёл, уламжлал, ялгаатай байдлыг ойлгоход тус нэмэр болох төдийгүй, хэлний мэдлэгээ сайжруулан, нийгмийн талаарх ойлголтоо нэмэгдүүлэх, олон улсад өрсөлдөх ур чадвартай, авьяастай, бүтээлч иргэнийг төлөвшүүлэх хэрэгцээ шаардлага үүсч байна.

Монгол Улсын хэмжээнд сургач солилцоо хөтөлбөрийг гадаадын улс оронд хэрэгжүүлдэг төрийн бус байгууллагууд нэлээд байна. Үүний нэг нь Зориг сан болон АНУ-ын Денвер Эгч Дүүс Хотын Зөвлөлтэй хамтран хэрэгжүүлж буй Люби Женкинс сургач солилцооны хөтөлбөр нь ерөнхий боловсролын сурагчдад манлайллын ур чадварыг эзэмшижүүлж нийгэмдээ хариуцлагатай, чадварлаг иргэн болон төлөвшихөд нь туслахад чиглэгдсэн хөтөлбөр юм. Уг хөтөлбөр нь Америк дахь Зориг сангийн ерөнхийлөгч Волтор Женкинсийн санаачлагаар 2004 оноос хойш одоог хүртэл хэрэгжүүлж байгаа бөгөөд 10, 11 дүгээр ангийн буюу 17 настны 20-25 хүүхдийг жилдээ хамруулдаг байна. Мөн нийслэлийн Хан-Уул дүүрэг БНСУ-ын өмнөд Генгсан аймгийн Хаман сумтай 2011 оноос хойш эгч дүүсийн найрсаг харилцаатай хамтран ажиллаж жилдээ 10 сургачийг сургач солилцоонд хамруулдаг байна.

Манай аймгийн хэмжээнд 2019 онд Монголын динозавр судлалын хүрээлэнгээс Булган сумын ерөнхий боловсролын сургуульд “Өсвөрийн судлаач” хөтөлбөрийг хэрэгжүүлж 4 сургачийг хамруулан 10 хоногийн хугацаанд АНУ-ын Калифорни мужийн Лос Анжелес хотод байрлах АЛФ палеонтологийн музейд зуны хөтөлбөрт хамруулсан. Мөн Америкийн байгалийн түүхийн музейд байрлах Монгол орноос 100 жилийн өмнө Роё Чапмен Эндрюсийн олборлосон палеонтологийн чухал олдворуудтай танилцсаны зэрэгцээ биологийн шинжлэх ухааны лабораторид сургалтад хамрагдаж, танилцах аялал хийсэн. Мөн сүүлийн жилүүдэд аймаг, сум хооронд, хөрш зэргэлдээ Дундговь аймагт 7 хоногийн хугацаатай сургач солилцоо арга хэмжээг зохион байгуулж, 33 сургачийг хамруулсан байна. Мөн 7 сургачийг Олон улсын Артек зуслан, Оросын холбооны улс, Америк, Япон улсын Засгийн газрын тэтгэлгээр тухайн улс оронд сургач солилцоонд хамрагдсан байна.

Өмнөговь аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны “Нутгийн хишиг” хөтөлбөрт ахлах ангийн сурагчдыг өндөр хөгжилтэй оронд сургах боломжийг бүрдүүлэх “Сургач солилцоо” хөтөлбөрийг батлуулан хэрэгжүүлэхээр тусгасан. Энэхүү хөтөлбөрөөр дамжуулан 13-18 настны хүүхэд, залуучуудыг дотоодын болон гадаадын хамтын ажиллагаатай сургуулиудад тодорхой хугацаанд суралцуулж, улс орны түүх соёл, зан заншил, байгаль, амьдрах орчин нөхцөлтэй танилцуулж, сургалтын үйл ажиллагааны талаар ойлголттой болох боломжийг олгоход чиглэнэ.

### Хоёр. Хөтөлбөрийн зорилго

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг богино хугацаанд гадаад, дотоодын сургуулиудад сургалтын хөтөлбөрт хамруулан тэдний бие даан хөгжих, мэдлэг чадвараа дээшлүүлэх, туршлага судлуулах, улс орон, аймаг, бусийн онцлог,

түүх, хэл соёл, сургалтын системтэй танилцуулах, гадаадын их дээд сургуульд элсэн суралцах боломжийг бүрдүүлэхэд оршино.

### **Гурав. Хөтөлбөрийн зорилт**

- 3.1. Дотоодын ерөнхий боловсролын болон хувийн өмчийн сургуулиудад сурагч солилцох;
- 3.2. Өндөр хөгжилтэй гадаадын улс орны сургуулиудад сурагч солилцох ;
- 3.3. Олон улсын болон дотоодын хүүхдийн зуслантай хамтран ажиллаж, хүүхэд залуучуудын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх;

### **Дөрөв . Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

- 4.1. Дотоодын ерөнхий боловсролын болон хувийн өмчийн сургуулиудад сурагч солилцох зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

4.1.1.Нийслэлийн хувийн болон улсын ерөнхий боловсролын сургуулиудтай хамтын ажиллагааг бий болгож, сурагч солилцох;

4.1.2.Их, дээд сургуулийн лицей сургуулиудад хүүхэд, залуучуудыг богино хугацаанд суралцуулах;

4.1.3.Бусад аймаг, сум, өөрийн аймгийн сумдын сургуулиудад сурагч солилцоо арга хэмжээг зохион байгуулах;

4.2. Өндөр хөгжилтэй гадаадын улс орны сургуулиудад сурагч солилцох зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

4.2.1.Гадаадын улс орны муж, хот, аймаг, сургуультай хамтын ажиллагааг бий болгож, сурагч солилцох;

4.2.2.Гадаад хэлний хөтөч хүүхдийг бэлтгэх клубийг сургуулиудад ажиллуулах;

4.2.3.Гадаад улс орнуудад сурагч солилцоо арга хэмжээнд хамрагдаж ирсэн хүүхдүүдийн сурсан мэдсэнийг бусад хүүхдүүдэд түгээх;

4.2.4.Төрийн бус байгууллагуудтай хамтран гадаад оронд сурагч солилцоогоор явах хүүхдийг бэлтгэх сургалтыг зохион байгуулах;

4.3 Олон улсын болон дотоодын хүүхдийн зуслантай хамтран ажиллах зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

4.3.1.Олон улсын болон дотоодын хүүхдийн зуслантай хамтын ажиллагааг бий болгож, сурагч солилцох;

4.3.2.Хүүхдийн хөдөлмөрч, бүтээлч хандлагыг бий болгож орон нутгийн онцлогийг харуулсан бэлэг дурсгалын бүтээлийн санг бий болгох;

4.3.3.Сурагч солилцоог харуулсан цуврал контент, нэвтрүүлэг хийх;

4.3.4.Хөдөлмөр зусландаа сурагч солилцох;

### **Тав. Хөтөлбөрийн болзол журам**

5.1. Сурагч солилцоонд хүүхдийг тэгш хамруулах боломжийг бүрдүүлж, мэдээллээр хангах;

5.2. Гадаад хэлний ярианы дунд түвшингээс дээш мэдлэгтэй байх;

5.3. Өмнөговь аймагт оршин суудаг, үндсэн харьяатай хүүхэд байх;

5.4. 13-18 насны хүүхдийг хамруулах;

5.5. Харилцааны зөв хандлагатай, бие даасан, өөрийгөө бусдад илэрхийльж

- 5.6. Нийгмийн идэвх, оролцоо сайтай, сайн дурын ажилд оролцдог байх;
- 5.7. Монгол Улс, Өмнөговь аймгийнхаа талаар, мөн өв соёл, уламжлалаа бусад улс, орон нутагт танилцуулах мэдлэг, мэдээлэлтэй байх;
- 5.8. Өөрийгөө хөгжүүлэх чин хүсэл, эрмэлзэлтэй байх;

**Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа**

6.1. Хөтөлбөрийг 2 үе шаттай хэрэгжүүлнэ.

6.1.1. Гадаад оронд хэрэгжүүлэх бэлтгэлийг хангах, дотоодод хэрэгжүүлж эхлэх 2021-2022 он./1 дүгээр үе/

6.1.2. Гадаад, дотоодод хэрэгжүүлэх 2022-2024 он./2 дугаар үе/

**Долоо. Хөтөлбөрийн үр дүн**

7.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ.

7.1.1. Нийслэл болон бусад аймаг, сумын сургуулиудтай хамтын ажиллагааг бий болгож, тэдний сургуулийн соёл, амьдралын хэв маяг, сургалтын онцлогоос суралцана.

7.1.2. Гадаадын өндөр хөгжилтэй улс орны сургуулиудтай хамтын ажиллагааг бий болгож, тэдний хэл соёл, ёс заншил, амьдралын хэв маяг, сургалтын онцлогоос танин мэдэж, гадаадын их дээд сургуульд суралцах боломж бүрдэнэ.

7.1.3. Олон улсын болон дотоодын хүүхдийн зуслантай хамтын ажиллагааг бий болгож, хүүхдийг хөгжүүлнэ.

7.1.4. Хүүхдийг бие дааж амьдрах, багаар ажиллах чадварыг эзэмшүүлнэ.

7.1.5. Бусад орны хүн ардын соёл, зан заншлыг хүндэтгэдэг, хүлээн зөвшөөрдөг, хүний эрхийг дээдэлдэг төлөвшил, хандлагыг бий болгоно.

**Найм. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт**

Зорилт	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Зорилтот түвшин
1	Хамтын ажиллагаатай болсон Нийслэлийн хувийн болон улсын ерөнхий боловсролын сургууль	тоо	0	8
	Дотоодын ерөнхий боловсролын болон хувийн өмчийн сургуулиудад сургач солилцоонд хамрагдсан хүүхэд	Тоо	33	120
	Хамтын ажиллагаатай болсон их, дээд сургуулийн лицей сургууль	Тоо	2	3
	Их, дээд сургуулийн лицей сургуулиудад суралцсан хүүхэд, залуучууд	тоо	8	20
2	Хамтын ажиллагаатай болсон гадаадын улс орны муж, хот, аймаг, сургууль	Тоо	4	5-6
	Гадаадын өндөр хөгжилтэй улс орон сургач солилцоонд хамрагласан хүүхэл	Тоо	7	10-15

	Гадаад хэлний хөтөч хүүхдийг бэлтгэх клуб	Too	2	14
	Хөтөлбөрт хамрагдсанаараа гадаадын их дээд сургуульд элсэн суралцах болсон хүүхэд	Too	0	2
3	Хамтын ажиллагаатай болсон Олон улсын болон дотоодын хүүхдийн зуслан	Too	1	5
	Хүүхдийн хөдөлмөрч, бүтээлч хандлагыг бий болгосон орон нутгийн онцлогийг харуулсан бэлэг дурсгалын бүтээлийн сан	Too	0	4
	Сурагч солилцоог харуулсан цуврал контент, нэвтрүүлэг	Too	0	12

### Ес. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэр

- 9.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ.
- 9.1.1 Орон нутгийн төсөв
  - 9.1.2 Төсөл хөтөлбөр, хандив тусламж
  - 9.1.3 Бусад эх үүсвэр

### Арав. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

10.1. Хөтөлбөрийг аймгийн Засаг даргын Тамгын газар, Боловсрол, соёл урлагийн газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Монголын их, дээд сургууль, хувийн болон улсын ерөнхий боловсролын сургууль, “Буянт хотхон” хүүхдийн зуслан, гадаадын улс орон, хүүхдийн зуслан, төрийн бус байгууллагууд хамтран хэрэгжүүлнэ.

### Арван нэг. Хөтөлбөрийн хэрэгжилтэд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээ

11.1. Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг тухайн оны 12 дугаар сард багтаан Хяналт, шинжилгээ-үнэлгээ дотоод аудитын хэлтэст хүргүүлнэ.

11.2. Хөтөлбөрийн хэрэгжилтэд Хяналт шинжилгээ-үнэлгээ, дотоод аудитын хэлтэс жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээг хийх бөгөөд Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг 1 жил тутамд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралд танилцуулна.

11.3. Шаардлагатай тохиолдолд хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш 18 сараас доошгүй хугацааны дараа үр дүнд суурилсан явцын болон хөндлөнгийн үнэлгээ хийлгэж болно.